



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 01 сарын 26 өдөр

Дугаар 24

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, 198,000,000.00 (нэг зуун ерэн найман сая) төгрөгийн балансын үнэ, 51,150,000.00 (тавин нэгэн сая нэг зуун тавин мянга) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан 1 ширхэг автомашиныг “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газарт балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Монголросцветмет” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат, “Засгийн газрын авто бааз” улсын төсөвт үйлдвэрийн газрын захирал Г.Чинзориг нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг балансаас балансад шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2021 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс /Д.Нарангэрэл/-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА  Д.НАРАНГЭРЭЛ

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2021 оны 01 дугаар сарын 24-ны өдрийн
24 дугаар тогтоолын хавсралт



**“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРААС “ЗАСГИЙН ГАЗРЫН АВТО БААЗ” УЛСЫН
ТӨСӨВТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр	Ашиглал тад орсон огноо	Тоо хэмжээ	Улсын дугаар	Арлын дугаар	Балансын нийт үнэ	Хуримт- лагдсан элэгдэл	Үлдэгдэл өртөг
						(төгрөг)		
1	Ниссан патрол Y62	2018.05.31	1	99-80 УАЕ	JNITANY62 Z0100252	198,000,000.00	51,150,000.00	146,850,000.00
НИЙТ ДҮН						198,000,000.00	51,150,000.00	146,850,000.00
						(нэг зуун ерэн найман сая)	(тавин нэгэн сая нэг зуун тавин мянга)	(нэг зуун дөчин зургаан сая найман зуун тавин мянга)